

**“MGL Forex Financial Services” ХХК**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо,
Экспресс тауэр, 12 давхар 1201 тоот

Утас: [976-70 1771 70](tel:976-70-1771-70)

Имэйл хаяг: account@mglforex.mn

Вэб: www.mglforex.mn

MGL FOREX арилжааны платформ ашиглах гэрээ, нөхцөл

Нэг талаас “MGL Forex Financial Services” ХХК (цаашид “MGL FOREX” гэх) Нөгөө талаас MGL FOREX арилжааны платформыг ашиглан олон улсын зах зээл дээр арилжаанд оролцож буй харилцагч Овогтой Регистрийн дугаар:..... (цаашид “Харилцагч” гэх, хамтад нь “Талууд” гэх) нар 1 MGL FOREX арилжааны платформ ашиглах гэрээ (Цаашид “Гэрээ” гэх)-г Монгол улсын холбогдох хууль тогтоомж, журмыг үндэслэн харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь харилцагч MGL FOREX арилжааны платформыг ашиглан олон улсын зах зээл дээр хийгдэх forex арилжаанд оролцох, түүний төлбөр тооцоог хийхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 MGL FOREX арилжааны платформын харилцагчдын төлбөр тооцоог Монголын арилжааны банкуудаар дамжуулан “MGL Forex Financial Services” саадгүй, түргэн шуурхай гүйцэтгэнэ.
- 1.3 Талуудын арилжаа хийх үед үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.
- 1.4 Харилцагч дансандаа орлого хийх, зарлага гаргахдаа өөрийн сонгосон банкны шимтгэлийн нөхцлийг бүрэн хариуцна.
- 1.5 Энэхүү гэрээ нь талуудын аль нэг тал санаачлага гаргаагүй бол хугацаагүй байгуулсанд тооцох бөгөөд харилцагч дансаа ашиглаагүй 6 сар болсон бол энэ тухай цахим шуудан, харилцагчийн холбоо барих утсаар мэдэгдсэний дараа арилжааны дансыг хаана.
- 1.6 Энэхүү гэрээг байгуулах үеийн арилжаа хийх нөхцөл өөрчлөгдсөн тохиолдолд харилцагчид цахим шуудан, харилцагчийн холбоо барих утас, өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдэгдэх ба харилцагч гэрээг цуцлах хүсэлт гаргаагүй бол шинэчлэгдсэн нөхцлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

ХОЁР. ХЭРЭГЛЭГДЭХ НЭР ТОМЬЁО

- 2.1 Гэрээнд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 2.1.1 “Арилжааны данс” trading account- MGL FOREX арилжааны платформ дээр нээлгэсэн харилцагчийн данс
 - 2.1.2 “Позиц” position – хийгдсэн арилжааг
 - 2.1.3 “Хөшүүрэг” leverage- харилцагч өөрийн хөрөнгийг үржүүлсэн дүнгээр арилжаа хийх боломжтой бөгөөд арилжааны хөшүүрэг 500 хүртэл байх ба харилцагчийн нээж болох позицийн дүн нь барьцаа хөрөнгийг 500 дахин үржүүлсэн дүнгээс хэтрэхгүй байхыг;
 - 2.1.4 “Арилжааны цаг” trade time – Улаанбаатарын цагаар даваа гарагийн 05:00 цагаас Бямба гарагийн 05:00 цаг хүртэл буюу олон улсын ажлын өдрийг;
 - 2.1.5 “Арилжааны ордер” order- Алдагдлыг хязгаарлах ба ашиг авах захиалга /Stop loss & Take profit/ харилцагч арилжаа хийхдээ ханш алдагдалтай чиглэлд алдагдлын хэмжээг багасгах, таамагласан ханш дээр хүрэхэд ашиг авах захиалгыг;
 - 2.1.6 “Арилжааны лот” lot size- (цаашид “арилжаалах валютын нэгж хэмжээ” гэх) гэж 1 lot =

- 100.000 тухайн суурь валюттай тэнцэхүйц хэмжээг;
- 2.1.7 “Ханшийн мэдээлэл” price quote- (цаашид “кросс” гэх) гэж платформ дээр тусгасан валютуудын хослол, металлууд, олон улсад арилжаалагддаг томоохон индексүүд, нефтийн тавааруудын худалдан авах/худалдах ханшийг тус тус ойлгоно.
- 2.1.8 “Balance” нээлттэй позиц ашиг алдагдлыг оруулахгүйгээр тооцсон дансны хөрөнгө
- 2.1.9 “Equity”- нээлттэй позицын ашиг алдагдлыг бодитоор оруулан тооцсон тухайн хугацаан дахь дансны бодит хөрөнгө
- 2.1.10 “Swap”- Нээлттэй позицын хоногийн хүүд төлж буй валютын хүүгийн зөрүүгийн төлбөр
- 2.1.11 “Margin”-арилжаа хийхэд сонгосон хөшүүргээс хамааран ашиглаж буй барьцаа хөрөнгө
- 2.1.12 “Free Margin”- гэдэг нь ашиглах боломжтой маржин хөрөнгийг хэлнэ

ГУРАВ. АРИЛЖАА ХИЙХ НӨХЦӨЛ

- 3.1 Харилцагч нь өөрийн байршуулсан хөрөнгийг сонгосон хөшүүргийн хэмжээнээс хамааруулан MGL FOREX арилжааны платформоор дамжуулж олон улсын зах зээлд валют, үнэт металл, нефтийн бүтээгдэхүүнүүд, голлох индексүүдийн арилжаа хийнэ.
- 3.2 Харилцагчийн арилжааны Стандарт данс нээлгэх доод хэмжээ USD 50.00 /тавь/ ам.доллар байна.
- 3.3 Харилцагчийн арилжааны Pro данс, Institutional данс нээлгэх доод хэмжээ USD 5,000.00 /таван мянга/ ам.доллар байна.
- 3.4 Харилцагч арилжаанд оролцохоос өмнө MGL FOREX арилжааны платформын гэрээтэй танилцаж, арилжаанаас үүдэн гарах эрсдэлийг бүрэн мэдсэн байна.
- 3.5 Харилцагч нь MGL FOREX арилжааны платформд хийгдсэн арилжааны нөхцлүүдийг бүрэн мэдсэний үндсэн дээр арилжаанд оролцно.
- 3.6 Арилжааны цаг нь олон улсын ажлын цагаар явагдна.
- 3.7 Харилцагч арилжааны дансандаа орлого хийхдээ “MGL Forex Financial Services” ХХК (“Эм жи эл форекс финаншл сервис” ХХК) –ны
Худалдаа хөгжлийн банкин дахь 499248960 тоот ам.долларын, 473017569 тоот төгрөгийн дансанд,
Хаан банкин дахь 5163 1030 83 тоот ам.долларын, 5163 1030 72 тоот төгрөгийн дансанд арилжааны хөрөнгийг шилжүүлэх бөгөөд гүйлгээний утга дээр нь өөрийн овог нэр, регистр, утасны дугаар, арилжааны дансны дугаарыг заавал бичнэ. Бусад этгээдээс төлбөр хүлээн авахгүй.
- Крипто валютаар зузаатгал хийх бол:**
Bitcoin (14i46k59vVwi9SAHvdqJSraqJTAQc2m49R),
Ethereum (0x58364e4e23736fd7250a0dbcac22583605d103fb),
Binance (0x58364e4e23736fd7250a0dbcac22583605d103fb),
Tether (0x58364e4e23736fd7250a0dbcac22583605d103fb) wallet-руу зузаатгал хийж болох ба тухайн үеийн зах зээлийн ханшаар крипто валютыг хөрвүүлэн арилжааны дансанд зузаатгал хийнэ. Зузаатгал хийхдээ account@mglforex.mn хаягруу өөрийн Wallet дугаар, форексийн арилжааны дансны дугаар, шилжүүлсэн криптовалютын дүнгээ илгээж баталгаажуулах ёстой. Зузаатгал хийхэд шимтгэл **0.5%**.
- 3.8 Харилцагч нь арилжааны данснаасаа хөрөнгө гаргах захиалгыг өөрийн баталгаат и-мэйлээс account@mglforex.mn хаягруу ирүүлнэ. MGL Forex нь харилцагчийн дансны үлдэгдэл, нээлттэй позиц, захиалгуудыг шалгасны үндсэн дээр боломжит хөрөнгийг харилцагчийн дотоодын банкин дахь дансанд шилжүүлнэ. Харилцагчаас өөр этгээдийн дансруу хөрөнгө шилжүүлэхгүй. **Криптовалютаар** зарлага хийхдээ өөрийн баталгаат и-мэйл хаягаас өөрийн wallet-ийн дугаарыг урьдчилан бүртгүүлсэн байх шаардлагатай ба урьдчилж бүртгүүлээгүй тохиолдолд аюулгүй байдлыг бодолцон зарлага гаргахгүй.
- 3.9 Харилцагчийн зарлагын гүйлгээг хийхдээ дотоодын банкуу хийгдэх гүйлгээ тутамд дүн харгалзахгүй **0.80 ам.долларын шимтгэл авна**. Гадаадын банкуу шилжүүлэх бол мөнгөн дүнгээс хамаарч шилжүүлэгч банкны гадаад гуйвуулгын шимтгэлийг суутган авна. **Крипто**

валютаар зарлага гаргахад шимтгэлгүй байх ба тухайн үеийн зах зээлийн ханшаар хөрвүүлэн зарлагыг дүнг тооцоолно.

ДӨРӨВ. ЭРХ ҮҮРЭГ

4.1 Харилцагч нь дараах эрхтэй:

4.1.1 Харилцагч нь MGL FOREX арилжааны платформын үндсэн нөхцлүүдийг зөвшөөрсний үндсэн дээр арилжааны данс нээлгэж дансандаа орлого хийх, данснаасаа зарлага гаргах эрхтэй.

4.1.2 Орлого болон зарлагын гүйлгээг хурдан шуурхай гүйцэтгүүлэх,

4.1.3 MGL FOREX арилжааны платформд ашиглаж болох бүхий л хэрэгслүүдийг өөрийн санаачлагаар ашиглах эрхтэй. (mirror trade, forex trading robots гэх мэт.)

4.1.4 Арилжааны платформ ашиглахтай холбоотой гарсан асуудлаа түргэн шуурхай шийдүүлэх.

4.1.5 Харилцагч нь арилжаанаас олсон ашиг, орлогын мэдүүлгээ өөрийн оршин суух харьяа татварын хэлтэстэй сайн дураараа мэдүүлэх.

4.2 Харилцагч нь дараах үүрэгтэй:

4.2.1 Өөрийн хийсэн болон өөрийн санаачлагаар холбосон автоматчилсан арилжааны үр дүнг бүрэн хариуцах.

ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1 Амралтын өдрийн дараах ханшийн тасралт: MGL FOREX-с шалтгаалаагүй хүчин зүйлээс болж ордерийн биелэлт хоцорсон, зах зээл дээрх гэнэтийн шок, амралтын өдрийн дараах ханшийн тасралт, гэх мэт аливаа ханшийн огцом хөдөлгөөнөөс үүдсэн хохирлыг “MGL Forex Financial Services” ХХК хариуцахгүй.

5.2 Харилцагч нь MGL FOREX-с өгсөн платформд нэвтрэх хэрэглэгчийн нэр ба нууц үгийг бусдаас бүрэн хамгаалах үүргийг хүлээх ба алдсаны улмаас үүсэх хохирлыг MGL FOREX хариуцахгүй.

5.3 Харилцагч нь өөрийнхөө мэдээллийн өөрчлөлтийг цаг тухайд нь MGL FOREX-д мэдэгдэх бөгөөд мэдээлэл саатсанаас үүссэн хохирлыг MGL FOREX хариуцахгүй.

5.4 MGL FOREX нь харилцагчид арилжааны зөвлөмж өгөхгүй.

5.5 Харилцагч өөрийн хийсэн, болон өөрийн санаачлагаар холбосон автоматчилсан арилжааны үр дүнг бүрэн хариуцна.

ЗУРГАА. БАТАЛГАА

6.1 Энэхүү гэрээ, нөхцлийг харилцагч зөвшөөрч данс нээлгүүлснээр хүчин төгөлдөр болсон гэж үзнэ.

6.2 Харилцагч нь эрх зүйн бүрэн чадамжтай байж, гэрээ, нөхцөлтэй бүрэн танилцаж хүлээн зөвшөөрсөн байна.

6.3 Харилцагч нь хийж байгаа бүх үйлдлийнхээ үр дагаврыг хүлээх чадвартай байна.

6.4 Харилцагч нь энэхүү гэрээг байгуулахдаа валютын болон үнэт металлын зах зээлд хөшүүрэг бүхий арилжаа хийхэд холбогдон үүсэх эрсдэл, арилжааны платформаар дамжуулан онлайн хэлбэрээр хийх хөшүүрэг бүхий арилжааны эрсдэлийг бүрэн ойлгосон байна.

6.5 Энэхүү гэрээний дагуу харилцагчаас өгсөн бүх баримт бичиг болон мэдээлэл, баталгаа нь бүгд үнэн зөв бөгөөд ямар нэг чухал зүйлийн талаар худал мэдээлээгүй болно.

6.6 Талууд гэрээ байгуулснаар мэдэх болсон нөгөө талынхаа бизнесийн үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээллийг шууд буюу шууд бусаар нөгөө талдаа хортой байдлаар ашиглахгүй, гуравдагч этгээдэд задруулахгүй байна.

6.7 Харилцагчийн хийсэн арилжааны бүх мэдээлэл нь MGL FOREX арилжааны платформ дээр электрон хэлбэрээр хадгалагдана. Арилжаа хийгдсэний дараа арилжааны баримт нь тус арилжааны хууль эрх зүйн үндэс бүхий баталгаа болно.

6.8 Гэрээтэй холбоотой бүхий л мэдэгдэл, зөвлөгөө, хүсэлтийг бичгээр болон албан ёсны и-мэйл

хаягаар илгээнэ.

- 6.9 MGL FOREX нь харилцагчийн мэдээллийг бусдад задруулахгүй, бусад зорилгоор ашиглахгүй, мэдээллийн нууцлалыг хадгална.
- 6.10 Харилцагчийн онлайнаар данс нээлгэсэн эсвэл өөрийн биеэр бичгээр байгуулсан гэрээ, нөхцөл ижилхэн хүчин төгөлдөр байна.

ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 7.1 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг эхлээд хэлэлцээр хийх замаар шийдвэрлэнэ.
- 7.2 Хэлэлцээр үр дүнд хүрээгүй бол маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ӨНДӨР ЭРСДЭЛИЙН САНУУЛГА:

Гадаад валютын арилжаа нь бүхий л түвшний хөрөнгө оруулагчдын хувьд эрсдэлтэй ба хөшүүрэг ашигласан байдаг тул та оруулсан хөрөнгөө хэсэгчлэн болон бүгдийг нь алдаж болно. Та уг арилжааг хийж эхлэхийн өмнө хөрөнгө оруулалтын зорилго, арилжааны туршлага, эрсдэл даах чадамж зэргийг тооцож үзэх шаардлагатай ба таны амьдралд нэн шаардлагатай санхүүгийн хөрөнгөөрөө арилжаанд оролцохгүй байх хэрэгтэй. Хэрэв та энэхүү зах зээл дээр ажиллаж байсан туршлагагүй бол санхүүгийн зөвлөгөө авах, туршилтын дансаар арилжаанд оролцож туршлага суусны дараа арилжаанд оролцох шаардлагатай.